



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2023/15/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Чингис хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Аудитор: Н.Туяа

Утас: 99799709

Цахим хаяг: www.open.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.04.04 № 319

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 423,342.2 мянган төгрөг, авлага 161,713.5 мянган төгрөг, бараа материал 74,886.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,688,865.5 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 3,348,807.9 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 569,621.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 484,784.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,116,950.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 15,447.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 81,129.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 10,502.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

232330416

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах, төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн хамт бэлтгэж ирүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,080,182.00	659,942.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	523,154.10	423,342.20
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	262,092.20	161,713.50
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	287,845.70	74,886.70
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	7,090.00	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,277,632.60	2,688,865.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	6,277,632.60	2,688,865.50
39200	Биет хөрөнгө		6,158,349.10	2,477,174.50
39300	Биет бус хөрөнгө	13	119,283.50	211,691.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		7,357,814.60	3,348,808.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		26,867.90	16,110.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	26,867.90	16,110.50
41300	Өглөг	17а, 17б	26,867.90	16,110.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,330,946.70	3,332,697.50
51	Засгийн газрын хувь оролцоо		7,330,946.70	3,332,697.50
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,613,120.90	339,285.60
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		0	339,285.60
51200	Хуримтлагдсан үр дүн		4,605,906.90	2,706,083.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,111,918.90	287,328.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		7,357,814.60	3,348,808.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,053,386.60	2,267,218.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО		368,996.90	467,818.80
110	Орлогын албан татвар		48,080.60	166,704.60
1100	Хувь хүний орлогын албан татвар		48,080.60	166,704.60
113	Хөрөнгийн албан татвар		120,015.10	105,477.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж		200,901.20	195,636.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,303,572.60	1,079,613.70
120	Нийтлэг татварын бус орлого		1,303,572.60	1,079,613.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,380,817.20	719,785.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,443,354.60	1,516,279.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,443,354.60	1,516,279.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,353,809.10	1,484,143.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,232,212.00	314,379.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		167,071.80	40,698.50

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		270,377.80	298,595.40
2104	Хангамж, бараа материалын зардал		97,164.50	60,945.10
2105	Нормативт зардал		207,029.10	452.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		25,847.60	31,913.60
2107	Томилолт, зочны зардал		8,473.50	14,407.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		68,113.20	331,056.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		277,519.60	391,695.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		89,545.50	32,135.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,610,032.10	750,938.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		233,525.30	4,779,836.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,376,506.70	-4,028,897.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		2,802,511.30	1,574,812.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО		368,996.90	467,818.80
110	Орлогын албан татвар		48,080.60	166,704.60
1100	Хувь хүний орлогын албан татвар		48,080.60	166,704.60
113	Хөрөнгийн албан татвар		120,015.10	105,477.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж		200,901.20	195,636.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		22,929.90	23,106.80
1181	Газрын төлбөр		7,062.10	44,861.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		170,909.20	127,668.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		111,938.20	335,802.40
120	Нийтлэг татварын бус орлого		111,938.20	335,802.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,321,576.20	771,191.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,201,283.00	1,280,584.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,201,283.00	1,280,584.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,057,832.40	1,208,074.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,229,922.00	376,787.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		168,545.70	49,752.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		270,377.80	396,546.00
2104	Хангамж, бараа материалын зардал		87,323.20	34,135.50
2105	Нормативт зардал		144,097.80	475
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		28,033.20	43,974.30
2107	Томилолт, зочны зардал		8,473.50	14,407.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		74,330.90	222,986.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		46,728.30	69,010.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		143,450.60	72,510.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		601,228.30	294,228.20

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		320,564.90	363,940.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		320,564.90	363,940.00
2200	Дотоод эх үүсвэрээр		320,564.90	363,940.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-320,564.90	-363,940.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		0	-30,100.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		0	30,100.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		280,663.40	-99,811.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		242,490.60	523,154.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		523,154.10	423,342.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,971,994.60	5,971,994.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-17,554.70	-17,554.70
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,954,440.00	5,954,440.00
8	Зарласан ногдол ашиг	0	0
9	Тайлант үеийн үр дүн	1,376,506.70	1,376,506.70
10	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,330,946.70	7,330,946.70
11	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	7,330,946.70	7,330,946.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	30,648.40	30,648.40
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,361,595.10	7,361,595.10
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0
19	Тайлант үеийн үр дүн	-4,028,897.60	-4,028,897.60
20	2022 оны 12-р сарын 31-аарх үлдэгдэл	3,332,697.50	3,332,697.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,465,665.4	1,289,181.2	176,484.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	976,649.6	961,796.2	14,853.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	944,493.5	929,647.3	14,846.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,348.2	312,730.9	6,617.3
210101	Үндсэн цалин	197,695.0	213,188.9	-15,493.9

210102	Нэмэгдэл	59,085.9	58,846.5	239.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,780.0	3,458.0	322.0
210104	Урамшуулал	10,042.4	8,299.5	1,742.9
210105	Гэрээт ажлын хөлс	48,744.9	28,938.0	19,806.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,729.0	40,423.2	1,305.8
210201	Тэтгэврийн даатгал	28,688.7	27,377.9	1,310.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,260.1	3,372.7	-112.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,608.1	2,589.8	18.3
210204	Ажилгүйдлийн даатгал	652.0	694.7	-42.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,520.1	6,388.1	132.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	303,285.7	297,215.2	6,070.5
210301	Гэрэл, цахилгаан	33,476.1	31,489.6	1,986.5
210302	Түлш, халаалт	267,475.6	264,675.6	2,800.0
210303	Цэвэр, бохир ус	2,334.0	1,050.0	1,284.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,699.6	29,610.8	88.8
210401	Бичиг хэрэг	4,564.9	4,560.5	4.4
210402	Тээвэр, шатахуун	19,831.0	19,728.4	102.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,881.3	1,887.7	-6.4
210404	Ном, хэвлэл	0.0	15.0	-15.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,422.4	3,419.2	3.2
2105	Нормативт зардал	475.3	475.0	0.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	475.3	475.0	0.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,984.9	43,974.3	10.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36.8	35.8	1.0
210604	Урсгал засвар	43,948.1	43,938.5	9.6
2107	Томилолт, зочны зардал	9,885.2	9,798.3	86.9
210702	Дотоод албан томилолт	9,885.2	9,798.3	86.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	129,536.1	128,897.1	639.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,315.8	125,254.4	61.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	569.3	0.0	569.3
210803	Даатгалын үйлчилгээ	449.9	449.7	0.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393.0	385.5	7.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66.5	66.0	0.5
210807	Газрын төлбөр	2,741.6	2,741.5	0.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,549.5	66,522.6	26.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,760.0	56,735.3	24.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,789.5	9,787.3	2.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,156.1	32,148.9	7.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,156.1	32,148.9	7.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,368.7	8,368.7	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,205.2	18,205.2	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,582.2	5,575.0	7.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	321,415.8	297,284.9	24,130.9
223001	Бусад хөрөнгө	321,415.8	297,284.9	24,130.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	167,600.0	30,100.0	137,500.0
230001	Эргэж төлөгдөх зээл	167,600.0	30,100.0	137,500.0

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,465,665.4	1,243,379.8	222,285.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,174,435.7	1,222,689.0	-48,253.3
320001	Орон нутгийн төсвөөс	1,053,249.6	1,101,502.9	-48,253.3
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	121,186.1	121,186.1	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	291,229.7	20,690.9	270,538.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,300.0	17,190.9	25,109.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,600.0	3,500.0	-900.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	246,329.7	0.0	246,329.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	265,464.5	-265,464.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	212,883.6	-212,883.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,129,172.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,129,172.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,755,345.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,380,220.00
210301	Гэрэл, цахилгаан	1,380,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,524,734.00
210401	Бичиг хэрэг	200,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,264,734.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,609,000.00
210702	Дотоод албан томилолт	4,609,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,923,503.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,923,503.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,317,888.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,317,888.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	373,827.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	111,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	262,827.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	262,827.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,384,584.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,384,584.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,538,900.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	53,595,684.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-744,588.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	744,588.06

5.1. Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн байгууллага 2, төрийн сангийн 1, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 1, тусгай сангийн 3, нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ, ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Байгаль хамгаалах сан, Баян-Овоо тохижилт ОНӨААТҮГ аудитын түүвэрт хамрагдсан болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 456,344.4 мянган төгрөгийн 17 алдаа, зөрчил илрүүлснээс 15,337.9 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 43,735.3 мянган төгрөгийн 3 зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 394,171.5 мянган төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

1. ИТХ 2,322.2 мянган төгрөгийн 3 худалдан авалтын, ОНХС-аас 98,625.3 мянган төгрөгийн 3 худалдан авалтын гүйлгээг төлбөрийн цахим баримтгүйгээр хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын "Маягт заавар батлах тухай" 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

2. Орлого үр дүнгийн тайланд цалингийн зардлыг ИТХ 3272.9 мянган төгрөгөөр, ЗДТГ 621.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй нэгтгэсэн алдаа илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 243,438.5 мянган төгрөгийн 7 арга хэмжээний тендерийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

Баян-Овоо тохижилт ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулаагүй, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлж сумын ИТХ-аар батлуулаагүй, сумын Засаг даргатай гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.1 дэх "1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ." 2.Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараах зүйлийг тусгана: 1/байгууллагын 3 жилийн хэтийн зорилт; 2/үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ; 3/нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулахад баримталсан бодлогын тухай тайлбар; 4/санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг; 5/төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг; 6/төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

2. Тайланд онд 280.0 мянган төгрөгөөр худалдан авсан Excel финансе санхүүгийн программ нь бараа материал, үндсэн хөрөнгийг бүртгэдэггүй, шаардлагатай журнал, дэлгэрэнгүй бүртгэлийг бүрэн хөтөлж гаргахгүй, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

3. Байгууллагын мөнгөн хөрөнгийг зарцуулахдаа банкны мөнгөн шилжүүлэгт 1, 2-р гарын үсгийг захирал О.Алтанбаатар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1. "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна: 20.1.3.аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

4. Баян-Овоо тохижилт ОНӨААТҮГ-ын захирал О.Алтанбаатар нь өөрийн гэр бүлийн хүнийг нярваар ажиллуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно. гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

5.2 Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа улсын төсөвт 4 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 төсвийн байгууллагын тайланд аудит хийж дүгнэлт гарган, ЭМТ, Соёлын төв аудитын түүвэрт хамрагдсан болно.

Аудитад хамрагдсан ЕБС, Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд "Платиниум прогресс аудит" ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 369,689.2 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлснээс 15,923.4 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 219,037.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 134,728.1 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Соёлын төв 1,500.0 мянган төгрөгийн санхүүгийн программ худалдан авахаар шилжүүлсэн ажил гүйлгээг данс бүртгэлд буруу тусгасан.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

2. Соёлын төв 291.7 мянган төгрөгийн орлогын албан татварыг илүү шилжүүлж авлагаар тусгаагүй, цалингаас суутгасан 396.3 мянган төгрөгийн хандивыг өглөгөөр тусгаагүй, цалингийн зардалд 1317.0 мянган төгрөгийн бараа материалын зардлыг бичсэн алдаа илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

3. Соёлын төв шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг 58.3 хувьтай мэдээлж, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 64,435.3 мянган төгрөгийн орлогын 9 гүйлгээ, хөрөнгө зарцуулахтай холбоотой 5,000.0 мянган төгрөгийн 1 тушаал, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

4. Соёлын төв 9,301.7 мянган төгрөгийн 6 гүйлгээг төлбөрийн цахим баримтгүй хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

5. ЭМТ тоног төхөөрөмж дансны элэгдлийг 6,762.7 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

6. Хүүхдийн цэцэрлэг мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 387.3 мянган төгрөгийн зөрүүтэй, санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 5,268.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

7. Хүүхдийн цэцэрлэг сумын Соёлын төвийн 2 дугаар сарын цахилгааны төлбөрийн 283.9 мянган төгрөгийг цэцэрлэгийн зардлаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөөгүй ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

8. Хүүхдийн цэцэрлэг цалингийн нэгдсэн системд оруулан тооцоолж бодогдоогүй 4,439.3 мянган төгрөгийн цалинг Төрийн албаны цалингийн нэгдсэн систем программд оруулан бодоогүй мөн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн зөрүүг тооцоолоогүй байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1дэх “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:”, Сангийн сайдын 2021 оны 109 дүгээр тушаал ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

9. ЕБС нь цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийг нийгмийн даатгалын тайлантай тулгахад 31,183.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь үйлчилгээний

ажиллагсдын эхний 5 сарын цалинг цалингийн нэгдсэн системээр олгоогүй, мөн ажиллагсдын албан татварын хөнгөлөлтийн зөрүүг тооцоогүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 109 дүгээр тушаал, ХХОАТ-ын тухай хуулийн 23.1 дугаар заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

10. ЕБС байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өмнөх оноос 20,368.8 мянган төгрөгөөр өссөн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.1 “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

11. ЕБС нь шилэн дансны нэгдсэн системд 20,535.5 мянган төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн хуулбарын 77 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 218,753.8 мянган төгрөгийг 35 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 10,502.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд:

1. Үр дүнгийн тайланд ЗДТГ, ИТХ-ын цалингийн зардлыг 3,722.4 мянган төгрөгөөр илүү, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 131.4 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 815.0 мянган төгрөгөөр, шатахууны зардлыг 2,332.0 мянган төгрөгөөр, аж ахуйн материал худалдан авах зардлыг 444,0 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна.
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэхдээ ЭМТ-ийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 6,779.6 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэснийг залруулсан.

Аудитаар зөрчил илрээгүй.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	10502.0			2	10502.0	2	10502.0				
ИТХ	1	3272.9			1	3272.9	1	3272.9				
ЗДТГ	1	621.0			1	621.0	1	621.0				
Баян-Овоо тохижилт	2	11444.0			2	11444.0	2	11444.0				
Дүн	11	41763.3			11	41763.3	11	41763.3				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	1	2322.2					1	2322.2				
ЗДТГ	1	18000					1	18000				
ОНХС	2	342063.8					2	342063.8				
Баян-Овоо тохижилт	6	12370.9			1	12370.9	5	0				
Дүн	14	419964.8			2	12654.8	12	407310				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ИТХ	1	31785.5						1	31785.5	
Дүн	3	319974.6					1	218753.8	2	101220.8
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ИТХ	1	10392.5					1	10392.5		
ЗДТГ	1	24071.6					1	24071.6		
Дүн	3	54832.9					2	34464.1	1	20368.8
Нийт дүн	6	374807.5					3	253217.9	3	121589.6

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	6	2	4		2			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	4		4					
4	ОНӨААН	1		1					
5	ТЕЗ								
	НИЙТ	11	2	9		2			